



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/162/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
(Дорноговь аймаг, Сайншанд хот)
2018 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 7052-2734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
Аудитын менежер:
Утас: 7052-3020 Цахим хаяг:Ц.Лүндэгмаа
Аудитор: Л.Баасандорж
Утас: 9905-5703 Цахим хаяг: baskal88@yahoo.com


Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	10
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	11
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	11
2.11	Шилэн дансны мэдээлэл	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3	Менежментийн захидал	13
	3.2 БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН БОЛОН ТУСЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	15
	3.3 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ.....	16
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	17
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	17
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	17
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	19
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20

Аудитын гэрчилгээ



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 54.3, 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч. АРИУНАА

1 Аудитын тайлан

1.1 Оршил

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Д.Ариунаад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018.12.27-наас 2019.02.20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар-ын хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.23-ны өдрийн 19 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

1.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

1.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургууль нь Хүүхэд хөгжлийн төвтэй, чанартай боловсрол – чадварлаг иргэн бэлтгэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургууль нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ерөнхий боловсролын үйлчилгээ
- Боловсролын нэг буюу хэд хэдэн түвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлэх
- Суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Бага дунд боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Үгүй

1.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ACOLOUS” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургууль дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

1.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь

материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 0 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

1.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардал*-ын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвийн санхүүжилтээр үйл ажиллагаа нь санхүүжүүлэгдэж, зарцуулагддагтай холбоотой юм.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2018 оны *Нийт зардал* 1,313,776.72 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 13,237.77 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь зардлын дүнд суурилсан эрсдэл үүсгэх ажил гүйлгээнүүд нь уг дүнгээс доош тохиолдолд аливаа шийдвэр гаргалтад үр нөлөөгүй гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

1.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	2,510.89	
3	Албан шаардлага өгсөн	1	606.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	4	3,116.89	

1.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1.8.1.1 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Тайлант хугацааны эцэст батлагдсан төсвөөс гарсан хэмнэлтээр авлага үүсгэж, холбогдох зардлыг бууруулан бүртгэсэн байна. Үүнд: Чандмань бадрал ХХК-д ирэх жилийн цэвэр бохир усны зардлын санхүүжилтэд 315,290 төгрөг, үдийн цайны санхүүжилтэд Даян сайн сайхан ХХК-д 2,195,600 төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь үнэн зөв байх, оршин байх, бодитой байх зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 45 дугаар зүйл “Төсвийн хэмнэлт”, 46 дугаар зүйл “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах журам” зэрэг заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тавих, актын төлбөрийг хүү торгуулийн орлогын дансанд 2019 онд батлагдсан төсвөөс төлж барагдуулах, авлага бүхий байгууллагатай холбогдох тооцоог дуусгах, хэрэгжилтийг 2019 оны 3 дугаар сарын 25-нд багтаан гүйцэтгэх

1.8.1.2 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

Спорт залны гэрээт бус үйлчлүүлэгчээс орж ирсэн орлогын 50%-ийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн улсын төсөвт шилжүүлж, үлдсэн 50%-ийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэлгүй шууд зарцуулсан байна.

Энэ нь бодитой байх, үнэн зөв байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байхаас гадна Сангийн сайдын 2011.06.07-ны өдрийн 129 дугаар тогтоол "Төсөвт байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.8 болон 3.1.6-р заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлж биелэлт болон хэрэгжилтийг 2019 оны 12 дугаар сарын 25-нд төрийн аудитын байгууллагад хүргүүлэх

1.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Нэмэлт санхүүжилтийн орлогын зарцуулалт
Бараа материалаарх хөрөнгийн ангилал

1.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 6 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1,234,991 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,234,988.87 мянган төгрөг буюу 99.99 хувьтай байгаа нь цалин хөлс 1,187 төгрөгөөр, НДШ 0.98 төгрөгөөр, тогтмол зардал 22 төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 210 төгрөгөөр тус тус хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

1.11 Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

1.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 80 хувьтай байна.

Өмнөх аудитаар 4 асуудал хөндсөн ба үүнд орлого, НДШ, ХЧТА-ны тэтгэмж, НББ-ийн бодлогын баримт бичиг зэрэг болно. Эндээс орлоготой холбоотой асуудал тайлант үеийн аудитаар дахин хөндөгдөж алдаатай зөрчилтэй асуудалд тооцогдсон байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

1.13 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургууль 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 БАТЛАГДСАН ТӨСӨВ ГҮЙЦЭТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт

Тайлант хугацааны эцэст батлагдсан төсвөөс гарсан хэмнэлтээр авлага үүсгэж, холбогдох зардлыг бууруулан бүртгэсэн байна. Үүнд: Чандмань бадрал ХХК-д ирэх жилийн цэвэр бохир усны зардлын санхүүжилтэд 315,290 төгрөг, Даян сайн сайхан ХХК-д 2,195,600 төгрөгийг тус тус шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8, 45, 46 дугаар зүйл, заалтууд болон Сангийн сайдын 2017 оны 216 тушаалаар батлагдсан “Төсвийн зардлын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-тай үл нийцэж байна.

Эрсдэл

Тайлант оны батлагдсан төсвөөс ирэх оны зардлыг санхүүжүүлэх, төсвийн хэмнэлтийг татан төвлөрүүлээгүйгээс мөнгөн хөрөнгө шамшигдах

Зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 7.7, 6.4.8, 45, 46 дугаар заалтууд, Сангийн сайдын 2017 оны 216 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн зардлын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ыг хэрэгжүүлж ажиллах

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Ариунаа

Төсвийн захирагчийн хариу

Сурагчдын амралт хойшлогдож цэвэр бохир ус, үдийн цайны зардлын хэмнэлт үүссэнийг тухайн компанид шилжүүлсэн болно. Цаашид өр авлагагүй анхаарч ажиллах болно. Даян сайн сайхан компаниас 2,195,600 төгрөгийг авч тогтоосон актын дагуу дансанд шилжүүлэх болно.

Үйлчлүүлэгч хариуг 2019.02.19-нд бичгээр ирүүлсэн болно.

3.2 БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН БОЛОН ТУСЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Илрүүлэлт

1. Спорт залны гэрээт бус үйлчлүүлэгчээс орж ирсэн орлогын 50%-ийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн улсын төсөвт шилжүүлж, үлдсэн 50% болох 606.0 мян.төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэлгүй шууд зарцуулсан байна.

Сангийн сайдын 2011.06.07-ны өдрийн 129 дугаар тогтоол "Төсөвт байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.8 болон 3.1.6-р заалтуудтай нийцэхгүй байна.

2. Эцэг эхчүүдийн хандиваар бий болсон 10.528 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь УСНББОУС 23-ийн 93-108 дах заалтуудыг зөрчиж байна.

Эрсдэл

Төсөвт байгууллагын хөрөнгө, нэмэлт орлогыг дутуу бүртгэх, ашиг сонирхлын зөрчил үүсэх

Эцэг эхчүүдийн хандиваар бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгаагүйгээс хөрөнгөнд тавигдах НББ-ээрх хяналт алдагдах

Зөвлөмж

1. Сангийн сайдын 2011.06.07-ны өдрийн 129 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах
2. Хандиваар хүлээн авсан хөрөнгийг УСНББОУС 23-ийн дагуу НББ-д тусгах, дотоод хяналтыг сайжруулах

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Ариунаа

Төсвийн захирагчийн хариу

1. Сургууль шинээр сургалтын үйл ажиллагаа эхэлсэнтэй холбогдуулан сургуульд шаардлагатай байсан бараа материал, эд хөрөнгийг худалдан авсан болно. Цаашид ийм зөрчил гаргахгүй анхааран ажиллах болно.
2. Аудитын зөвлөмжийн дагуу НББ-д тусгаж эхэлсэн, хойшид хөрөнгөд бүртгэлд авч байхыг нярав, нягтлан бодогч нарт хэлж санууллаа.

Үйлчлүүлэгч хариуг 2019.02.19-нд бичгээр ирүүлсэн болно.

3.3 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт

Бараа материалаарх хөрөнгөнд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэгдсэн байна. Номын фондыг бараа материалаар ангилан бүртгэсэн байна. Тайлант хугацаанд худалдан авсан үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материалаар хүлээн зөвшөөрсөн байна.

Энэ нь Сангийн Сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын нэгдүгээр хавсралтын 4.15 дугаарт зааснаар “Бараа материал гэдэг нь байгууллагын хэвийн үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх материал буюу хангамжийн зүйлс, худалдах зориулалтаар хадгалагдаж байгаа (улсын нөөцийн бараа зэрэг) бэлэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, үйлдвэрлэлийн процесст байгаа хагас боловсруулсан бүтээгдэхүүн зэрэг болно” гэсэн заалтад нийцэхгүй байна.

Эрсдэл

Хөрөнгийн буруу ангилснаас байгууллагын хөрөнгийн ашиглалтад тавигдах хяналт сулрах, хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах

Зөвлөмж

Сангийн Сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Ариунаа

Төсвийн захирагчийн хариу

Гарсан зөрчлийг Өмч хамгаалах зөвлөлд танилцуулж, алдаа дутагдлыг арилгуулах тал дээр анхаарч ажиллаж байна.

Үйлчлүүлэгч хариуг 2019.02.19-нд бичгээр ирүүлсэн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 3-р сарын 25-аас 2019 оны 12 дугаар сарын 25-ны дотор үе шаттайгаар ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ч.АРИУНАА

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Ц.ЛҮНДЭГМАА

БЭЛТГЭСЭН: АУДИТОР:

Л.БААСАНДОРЖ

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	190,115,152.00	200,494,005.40
33	АВЛАГА	3,718,264.00	3,654,517.40
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,297,664.00	1,143,627.40
335	Бусад авлага	2,420,600.00	2,510,890.00
3351	Байгууллагаас авах авлага	2,420,600.00	2,510,890.00
35	БАРАА МАТЕРИАЛ	186,396,888.00	196,839,488.00
351	Түүхий эд материал	26,747,383.00	28,016,183.00
35110	Тусгай зориулалттай материал	26,747,383.00	28,016,183.00
354	Хангамжийн материал	159,649,505.00	167,698,305.00
35410	Бичиг хэргийн материал	7,137,189.00	7,689,789.00
35420	Аж ахуйн материал	149,650,556.00	157,950,956.00
35440	Түлш, шатах тослох материал	380,000.00	200,000.00
35450	Барилгын засварын материал	30,000.00	48,200.00
35470	Бусад хангамжийн материал	2,451,760.00	1,809,360.00
35600	Мал амьтад	00.00	1,125,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	273,425,619.92	3,972,186,939.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	273,425,619.92	3,972,186,939.07
392	Биет хөрөнгө	272,501,619.92	3,779,262,939.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	00.00	3,578,291,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-9,939,697.22
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	184,909,531.17	198,726,553.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	-46,640,979.02	-103,059,822.86
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	135,663,040.00	130,137,640.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,350,402.23	-26,869,164.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-264,000.00
39217	Ном	9,280,430.00	9,600,430.00
393	Биет бус хөрөнгө	924,000.00	192,924,000.00
39301	Программ хангамж	924,000.00	924,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	192,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	463,540,771.92	4,172,680,944.47
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,112,437.21	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,112,437.21	00.00
413	Өглөг	3,112,437.21	00.00
4136	Бусад өглөг	3,112,437.21	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	3,112,437.21	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	460,428,334.71	4,172,680,944.47
51	Засгийн газрын хувь оролцоо	460,428,334.71	4,172,680,944.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	00.00	3,770,291,000.00
51101	Өмч: - төрийн	00.00	3,770,291,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	460,428,334.71	402,389,944.47
51210	Өмнөх үеийн үр дүн	460,428,334.71	453,528,438.65
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-51,138,494.18
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	463,540,771.92	4,172,680,944.47

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,015,856,646.50	1,272,638,228.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,900,322.50	37,647,228.38
120	Нийтлэг татварын бус орлого	59,900,322.50	37,647,228.38
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	59,900,322.50	37,646,228.38
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	18,054,506.00

Дорноговь аймгийн Замын-үүд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	59,900,322.50	19,591,722.38
120009	Бусад орлого	00.00	1,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	14,978,424.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	940,977,900.00	1,234,991,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,978,424.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,978,424.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	982,053,102.23	1,323,776,722.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	982,053,102.23	1,323,776,722.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	917,511,649.23	1,263,727,094.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	444,766,245.41	742,923,925.48
210101	Үндсэн цалин	315,601,427.00	498,249,184.00
210102	Нэмэгдэл	116,744,464.00	176,924,010.00
210104	Урамшуулал	12,420,354.41	67,750,731.48
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,664,351.00	86,525,723.14
210201	Тэтгэврийн даатгал	33,058,841.00	57,985,123.47
210202	Тэтгэмжийн даатгал	4,722,692.00	5,708,119.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,770,475.00	7,135,149.92
210204	Ажилгүйдлийн даатгал	919,302.00	1,427,029.98
210205	Эрүүл мэндийн даатгал	9,193,041.00	14,270,299.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	332,255,915.00	336,747,188.00
210301	Гэрэл, цахилгаан	4,260,220.00	11,621,890.00
210302	Түлш, халаалт	320,145,007.00	312,873,558.00
210303	Цэвэр, бохир ус	7,842,188.00	12,251,740.00
210304	Байрны түрээс	8,500.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,189,058.80	6,808,096.00
210401	Бичиг хэрэг	2,193,720.00	2,984,882.00
210402	Тээвэр, шатахуун	180,000.00	580,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	748,669.00	963,714.00
210404	Ном, хэвлэл	32,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,000.00	218,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,874,669.80	2,061,200.00
2105	Нормативт зардал	1,162,115.00	440,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	503,715.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	658,400.00	440,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,559,341.30	1,984,400.00
210604	Урсгал засвар	13,559,341.30	1,984,400.00
2107	Томилолт, зочны зардал	991,600.00	1,986,700.00
210702	Дотоод албан томилолт	991,600.00	1,986,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,235,430.00	1,500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,235,430.00	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,687,592.72	84,811,061.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,499,606.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,248,300.00	2,786,986.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	62,439,292.72	80,524,469.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,541,453.00	60,049,627.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,235,600.00	60,046,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,278,800.00	53,184,100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	6,862,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,956,800.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,305,853.00	3,127.98
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,305,853.00	3,127.98
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	33,803,544.27	-51,138,494.18
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	33,803,544.27	-51,138,494.18

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	955,956,324.00	1,253,046,506.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	18,055,506.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	18,055,506.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	18,054,506.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	18,054,506.00
120009	Бусад орлого	00.00	1,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	955,956,324.00	1,234,991,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	940,977,900.00	1,234,991,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,978,424.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,978,424.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	916,055,904.00	1,253,046,506.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	916,055,904.00	1,253,046,506.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	850,550,651.00	1,193,221,378.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	449,215,347.00	743,673,813.00
210101	Үндсэн цалин	315,550,321.00	498,249,184.00
210102	Нэмэгдэл	117,032,900.00	176,924,010.00
210104	Урамшуулал	16,632,126.00	68,500,619.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,705,800.00	85,621,799.02
210201	Тэтгэврийн даатгал	29,721,871.00	57,081,199.35
210202	Тэтгэмжийн даатгал	4,245,980.00	5,708,119.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,396,783.00	7,135,149.92
210204	Ажилгүйдлийн даатгал	849,197.00	1,427,029.98
210205	Эрүүл мэндийн даатгал	8,491,969.00	14,270,299.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	332,247,415.00	337,062,478.00
210301	Гэрэл, цахилгаан	4,260,220.00	11,621,890.00
210302	Түлш, халаалт	320,145,007.00	312,873,558.00
210303	Цэвэр, бохир ус	7,842,188.00	12,567,030.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,658,259.00	4,618,090.00
210401	Бичиг хэрэг	607,100.00	799,940.00
210402	Тээвэр, шатахуун	560,000.00	400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	748,669.00	898,530.00
210404	Ном, хэвлэл	387,000.00	501,320.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,000.00	218,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,195,490.00	1,800,000.00
2105	Нормативт зардал	2,660,800.00	1,800,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	360,800.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,300,000.00	1,800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,156,000.00	4,216,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	3,156,000.00	2,716,100.00
2107	Томиллолт, зочны зардал	991,600.00	1,386,700.00
210702	Дотоод албан томиллолт	991,600.00	1,386,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,235,430.00	2,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,235,430.00	2,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,680,000.00	12,842,398.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	750,000.00	3,547,934.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,930,000.00	9,294,464.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,505,253.00	59,825,127.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	63,199,400.00	59,822,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	37,699,400.00	52,959,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан	00.00	6,862,400.00

Дорноговь аймгийн Замын-үүд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,500,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,305,853.00	3,127.98
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,305,853.00	3,127.98
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>39,900,420.00</u>	<u>00.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>39,900,420.00</u>	<u>00.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>39,900,420.00</u>	<u>00.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	39,900,420.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	39,900,420.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-39,900,420.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-134,504,000.00	00.00

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	460,428,334.71	460,428,334.71
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-6,899,896.06	-6,899,896.06
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	453,528,438.65	453,528,438.65
Тайлант үеийн үр дүн	3,770,291,000.00	-51,138,494.18	3,719,152,505.82
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,770,291,000.00	402,389,944.47	4,172,680,944.47

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ЭЗ-ийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,234,991,000.00	1,234,988,872.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,234,991,000.00	1,234,988,872.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,175,169,000.00	1,175,166,872.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	732,848,600.00	732,847,413.00
210101	Үндсэн цалин	487,424,700.00	487,422,784.00
210102	Нэмэгдэл	176,924,200.00	176,924,010.00
210104	Урамшуулал	68,499,700.00	68,500,619.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,621,800.00	85,621,799.02
210201	Тэтгэврийн даатгал	59,261,300.00	57,081,199.35
210202	Тэтгэмжийн даатгал	6,590,100.00	5,708,119.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,272,100.00	7,135,149.92
210204	Ажилгүйдлийн даатгал	1,318,000.00	1,427,029.98
210205	Эрүүл мэндийн даатгал	13,180,300.00	14,270,299.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	337,062,500.00	337,062,478.00
210301	Гэрэл, цахилгаан	11,900,000.00	11,621,890.00
210302	Түлш, халаалт	314,560,900.00	312,873,558.00
210303	Цэвэр, бохир ус	10,601,600.00	12,567,030.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,618,300.00	4,618,090.00
210401	Бичиг хэрэг	800,000.00	799,940.00
210402	Тээвэр, шатахуун	400,000.00	400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	898,530.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	501,320.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн	218,300.00	218,300.00

Дорноговь аймгийн Замын-үүд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

устгал, ариутгал			
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	1,800,000.00
2105	Нормативт зардал	1,800,000.00	1,800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,800,000.00	1,800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,931,100.00	2,931,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,431,100.00	1,431,100.00
2107	Томилолт, зочны зардал	1,386,700.00	1,386,700.00
210702	Дотоод албан томилолт	1,386,700.00	1,386,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,500,000.00	1,500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,500,000.00	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7400000.00	7399292.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,400,000.00	1,399,328.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,000,000.00	5,999,964.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59822000.00	59822000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	59,822,000.00	59,822,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	52,959,600.00	52,959,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,862,400.00	6,862,400.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,234,991,000.00	1,234,991,000.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,234,991,000.00	1,234,991,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,234,991,000.00	1,234,991,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	87.00	87.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	59.00	59.00
620003	Үйлчлэх ажилтан	27.00	27.00